

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 22 ДУГААР ЗҮЙЛИЙН 22.1 ДЭХ ХЭСГИЙН ТАЛААР ГАРГАСАН ИРГЭНИЙ ӨРГӨДЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2014.04.30

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд 2013 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр нэр бүхий иргэнээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт “Мэргэшсэн нягтлан бодогчид сар тутам мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгоно. Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг Засгийн газар тогтооно.” гэж заасан нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг эрхэлсэн ажил, албан тушаал, боловсролоор нь ялгаварлан гадуурхах үл болох тухай хуулийн заалтуудыг зөрчиж байна гэж үзэж өргөдөл гаргасан.

Иргэний өргөдлийг УИХ-ын гишүүн Ж.Батзандан, Н.Батцэрэг нар Өргөдлийн байнгын хорооны 2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан журамд заасны дагуу судлан дараах санал, дүгнэлтийг боловсруулан танилцуулж байна.

Нэг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль нь 2001 оны 12 дугаар сарын 13-ны өдөр батлагдаж, нийт 6 удаагийн нэмэлт өөрчлөлтүүд /[2011-12-23](#), [2010-06-24](#), [2010-06-10](#), [2006-12-15](#), [2003-05-15](#), [2002-07-10](#)/ орсон байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт **“Мэргэшсэн нягтлан бодогчид сар тутам мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгоно. Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг Засгийн газар тогтооно.”** гэж заасны дагуу Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 258 тоот тушаалаар “Нэмэгдэл олгох тухай” журмыг баталсан. Энэхүү журамд мэргэжлийн зэргийн нэмэгдлийг дараах байдлаар тооцож олгохоор зохицуулсан:

2.1.Мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг доорх төрийн болон аж ахуйн байгууллагад ажиллаж буй мэргэшсэн нягтлан бодогч нарт олгоно. Үүнд:

- төрийн захиргааны болон үйлчилгээний алба, төрийн тусгай албанд **мэргэжлээрээ** ажиллаж байгаа
- төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа

2.2.Мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг ажлын үр дүнтэй уялдуулан тухайн албан тушаалын сарын цалингийн хэмжээнээс **15 хувиар тооцон сар бүр олгоно.**

Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтыг Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан шалгалтын комисс “Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт” ТББ-тай хамтран зохион байгуулж, Сангийн сайдын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 133 тоот тушаалаар баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын журам”-ын 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт зааснаар 2 жилийн хугацаагаар олгож байна. Мөн холбогдох шалгалтуудыг өгч 5 жилийн, цаашлаад хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан

бодогчийн гэрчилгээг үе шаттайгаар олгож байна.

Байнгын хорооноос холбогдох лавлагаа мэдээллийг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс гаргуулан авлаа. Улсын хэмжээнд нийт 3281 мэргэшсэн нягтлан бодогч байгаа бөгөөд төсөвт байгууллагад 1395, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид 460, аж ахуйн нэгжид 1426 мэргэжлээрээ ажиллаж байгаа нөхцөлд уг мэргэжлийн зэргийн нэмэгдлийг авах эрхтэй байна. Мэргэшсэн нягтлан бодогчдын 86.5 хувь нь нэмэгдэл авч байна.

Олон улсын нягтлан бодогчдын холбооны гишүүн 103 улсад энэ төрлийн нэмэгдлийг олгож байгаа бөгөөд Монгол Улс 1969 онд соёрхон баталсан Алагчлалгүй байх тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенцид “тодорхой ажлын онцлогтой холбоотой тавигдах шаардлагад үндэслэн ялгаварлах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үйлдлийг алагчлах хэмээх ойлголтод хамааруулахгүй” гэж заасан байна.

Харин ажил олгогчийн хувьд зарим хүндрэлийг үүсгэж байна. Жишээ нь хэд хэдэн нягтлан бодогч ажиллуулдаг байгууллагын хувьд мэргэшсэн нягтлан бодогч ажиллуулах шаардлагагүй ажлын байран дээр мэргэшсэн нягтлан бодогчийг ажиллуулахад илүү зардал гарах учраас ажилд авахгүй байх, эсвэл нэмэгдлийг өгөхгүй байх зэрэг зөрчил үүсэж болохоор байна.

Хоёр. Санал, дүгнэлт

Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 258 тоот тушаалаар баталсан “Нэмэгдэл олгох тухай” журмын 2.1 дэх хэсэгт “Мэргэшсэн нягтлан бодогчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг доорх төрийн болон аж ахуйн байгууллагад ажиллаж буй мэргэшсэн нягтлан бодогч нарт олгоно...” гэж заасан нь ажил олгогчийн зүгээс тавигдах бодит шаардлагыг харгалзахгүй байна. Иймд дээрх журамд заасан нэмэгдлийг олгохдоо тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг харгалзах, мэргэжлээрээ ажиллаж буй гэдэгт ямар ажлын байрууд хамаарахыг тодорхой болгох чиглэлээр өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

Улсын Их Хурлын гишүүн
Улсын Их Хурлын гишүүн

Ж.Батзандан
Н.Батцэрэг